

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2005 оны 5 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Мэргэжлийн байгууллагуудын үйл
ажиллагааны шалгуур
үзүүлэлтүүдийг батлах тухай

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 11, 12, 15.3; “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 20, 22.2, 24.2, 25.2, 27.1, 28.1 дэхь заалтуудыг үндэслэн Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь :

НЭГ. Мэргэжлийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн шаардлага болон хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтаар баталсугай.

ХОЁР. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн дүгнэх аргачлалыг тэдэнд хүргүүлж энэ дагуу жил бүр дүгнэн Хорооны хуралдаанд хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллахыг ЗЗЗХ /Ц.Норовдондог/-т үүрэг болгосугай.

ГУРАВ. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамба/-нд даалгасугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ

Үнэт цаасны хорооны 2005 оны
5 дугаар сарын 27-ны өдрийн
30 дугаар тогтоолын хавсралт

АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ТООЦОЖ ДҮГНЭХ ЖУРАМ

ҮЦХ-ны 2005.05.27-ны өдрийн 30-р тогтоолын дагуу арилжаа эрхлэх байгууллагын шалгуур үзүүлэлтийг доорхи журмын дагуу дүгнэнэ.

1-р үзүүлэлт: Тухайн жилийн үнэт цаасны гүйлгээний дүнг өнгөрсөн оноос өссөн буурсныг тоо болон хувиар гаргаж харьцуулна.

2-р үзүүлэлт: Хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувьтай тэнцэх эрсдлийн санг байгуулж тусгай дансанд байршуулсан гүйцэтгэлийг тооцон тоо болон хувиар гарган тавигдсан шаардлагыг хангаж буй эсэхийг дүгнэх.

3-р үзүүлэлт: Биржийн /арилжааны байгууллагын/ орлогыг шимтгэл, хураамжийн болон бусад орлогын дүнгээр тооцож өнгөрсөн оноос өссөн /буурсан/ тоо хэмжээг гаргах ба мөн харьцуулж хувиар гарган жишиж тооцно.

4-р үзүүлэлт: Биржийн олсон орлогоос, гарсан зардал болон татварыг хасаж цэвэр ашгийг гарган, төлөвлөсөн хэмжээ болон өнгөрсөн онтой харьцуулан дүгнэнэ.

5-р үзүүлэлт: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2-д заасан жишээг /11/ үүргийг бүрэн биелүүлсэн эсэхийг заалт бүрээр гарган хэдэн үүргээс хэдийг нь биелүүлсэнийг тоогоор гарган, харьцуулж биелэлтийн хувийг тогтооно.

6-р үзүүлэлт: Хуулиар хүлээсэн онцлог чиг үүргийн биелэлтийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.3-д заасан /3/ 22.3-г заасан /4/ үзүүлэлтээр гаргаж хэдээс хэдийг биелүүлсэнийг тоо, хувиар гарган өнгөрсөн онуудтай нь харьцуулна.

7-р үзүүлэлт : ҮЦЗЗТХ-ийн 19.2.4, 19.2.5, 21.3.3, 22.3.4-р заалтууд болон бусад холбогдох заавар, журмыг үндэслэн гаргаж ирүүлбэл зохих мэдээ, судалгааг хугацаанд нь үнэн зөв чанартай гаргаж ирүүлсэн байдлыг үндэслэн хэдээс хэдийг ирүүлсэн тоогоор болон хувиар гарган тооцно.

8-р үзүүлэлт: Ээлжит шалгалтаар болон мэдээ мэдээллийг үндэслэн хийсэн үзлэг шалгалт, хууль, журам, тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргах явцад илэрсэн зөрчил дутагдлын тоо, түүний хор хохирлын хэмжээг тооцож, энэ үзүүлэлтийн биелэлтийг гаргана.

9-р үзүүлэлт: Гишүүн Брокер, дилерийн компаниудыг биржээс тогтоосон шалгуур үзүүлэлтээр сар бүр байр эзлүүлэн дүгнэсэн байдал. Тэдэнтэй гэрээ байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн байдлыг үндэслэн дүгнэнэ. БДК-иудын жилийн турш хэдэн удаа арилжаанд оролцсон тоо, нийт арилжааны дүнд тэдгээр БДК- тус бүрийн эзлэх хувь зэрэг үзүүлэлтээр байр эзлүүлэн дүгнэж, байгаа байдал зэргийг үндэслэнэ.

10-р үзүүлэлт: Хорооноос ҮЦЗЗТ болон Компанийн тухай хууль, тогтоол шийдвэр, журмуудад мэдээлэл сурталчилгааны талаар хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилтийг тооцож

биелэлтийг дүгнэнэ. Үүнд: Тендер санал, шинээр гаргасан үнэт цаас, бондын талаар сурталчилгаа олон нийтэд арилжааны явц болон бусад мэдээллийг хүргэсэн байдал. ХК-ийн хувь нийлүүлэгчдээс хүссэн мэдээллийг хүргэж буй байдлыг тооцож дүгнэнэ.

11-р үзүүлэлт: Тухайн жилд гаргасан тогтоол шийдвэрийн дагуу өгөгдсөн үүрэг, түүнээс хэд нь биелэгдсэнийг хэлтсүүд нэг бүрчлэн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага ТТХ-ийн төв, БДК- нэг бүрээр тоо , хувиар гаргаж биелэлтийг дүгнэнэ.

ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН /ХӨРӨНГИЙН БИРЖ,
ДИЛЕРҮҮДИЙН АРИЛЖААНЫ ТӨВ / ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хууль, журмаар тавигдах шаардлага	Тайлбар, үндэслэл
1	Үнэт цаасны гүйлгээний дүн / нийт үнэт цаас	Сая. төг	Тухайн жилд хийгдсэн гүйлгээний дүн, жилийн эцсийн мэдээ, тайлан , тэнцэлтэй тохирч байх	Арилжаа эрхлэх байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн харуулна.
2	Эрсдлийн сан	Сая. төг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсан байх	Хорооны 2003.08.06-ны өдрийн 59 тоот тогтоолоор баталсан түр журмын дагуу
3	Биржийн орлого	Сая. төг	Шимтгэл хураамж болон бусад орлогоор зардлаа бүрэн нөхөж байх	ҮЦЗЗТ хуулийн 22.1
4	Ашиг/+, алдагдал/-/	Сая. төг	Үр ашигтай ажиллах	--
5	Хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт	Тоо, хувь	Хуулиар хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж тайлагнах	ҮЦЗЗТ хуулийн 19.2-т заасан /11/ үүрэг
6	Хуулиар хүлээсэн онцлог чиг үүргийн биелэлт	Тоо, хувь	Хуулиар хүлээлгэсэн онцлог чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж тайлагнах	ҮЦЗЗТ хуулийн 21.3/3/, 22.3/4/-т тус тус заасан үүрэг
7	Тайлан тэнцэл, мэдээ судалгааг зохих журмын дагуу гаргаж ирүүлсэн байдал	Тоо, хувь	Холбогдох хууль, заавар журмаар болон албан тоотоор шаардсан мэдээ, судалгааг хугацаанд нь ирүүлэх	ҮЦЗЗТ хуулийн 19.2.1-19.2.4, 19.2.5 дахь заалт
8	Тайлангийн жилд гаргасан зөрчил, дутагдлын бууралт	Тоо; өсөлт, бууралтын хувь	Хууль, журмыг хатуу мөрдөж зөрчил дутагдал гаргахгүй байх	ҮЦЗЗТ хууль, холбогдох дүрэм, журмаар тавигдсан үүргийн хэрэгжилт

9	Гишүүн брокер, дилерийн компанитай гэрээ байгуулж хэрэгжүүлсэн байдал	Тоо, хувь	Тухайн жилд гэрээ байгуулж дүгнэн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх	БДК-иудын сар бүр байр эзлүүлэн дүгнэх, гэрээгээр тэдний өмнө, хүлээсэн үүргээ биелүүлсэн байдал
10	Мэдээлэл сурталчилгаа хийсэн байдал	Тоо, хувь	Хууль, тогтоомжийн дагуу арилжааны мэдээ, тендер санал, үнэт цаасны үнэ ханш шинээр болон нэмж гаргасан үнэт цаасны талаархи мэдээллийг нийтэд хүргэх	ҮЦЗЗТ/ 19.2.4, 21.3.3, 22.3.9/ , Компанийн тухай хууль, журмын холбогдох заалтууд
11	Тогтоол, шийдвэрийн биелэлт	Тоо, хувь	Тухайн жилд гарсан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж дүнг мэдээлэх	ҮЦЗЗТ хуулийн холбогдох заалтууд

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ХАДГАЛАМЖИЙН ТӨВИЙН
/БАЙГУУЛЛАГЫН/ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хууль журмаар тавигдсан шаардлага	Тайлбар, үндэслэл
1	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ	Хувь	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 75 хувиас доошгүй хэмжээтэй байх	ҮЦХ-ны Хорооны 2003.08.06-ны өдрийн 59 тоот тогтоолоор батлагдсан түр журам
2	Эрсдлийн сан	Сая. төг болон хувиар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувьтай тэнцүү хэмжээгээр байгуулах	ҮЦХ-ны Хорооны 2003.08.06-ны өдрийн 59 тоот тогтоолоор баталсан түр журам
3	Үнэт цаасны гүйлгээний дүн	Мян. төг	Урд жилүүдээс өсгөх буюу ТГТХТ ХХК-ийн зардлыг нөхөхүйц орлого оруулах хэмжээний гүйлгээ хийх /өсөлттэй байх/	ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 24.1; 25;
	Үнэт цаас гаргагч болон бусад этгээдүүдтэй байгуулсан гэрээний дагуу хийсэн гүйлгээ	Мян. төг	Ногдол ашиг, ногдол хувь, тараах, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдсон бусад төрлийн үйлчилгээг зохих, хууль журмын дагуу хугацаанд нь гүйцэтгэх	ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 24, 25-р зүйл, холбогдох журам, бусадтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг
	Ашиг/+/ , алдагдал /-/	Мян. төг	Үр ашигтай ажиллах	ТӨХ-гүйцэтгэх захирлын хооронд байгуулсан гэрээний биелэлтээр
4	Санхүүгийн төлбөрийн чадварын зохист харьцааны коэффициент	Коэфф.	Өр төлбөрийн хэмжээ аль болох бага байхад чиглэгдэнэ	Санхүүгийн тайлан тэнцлийг үндэслэн гаргана
5	Хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт	Тоо, хувь	Хууль, журамд заасан үүргийг биелүүлэх	ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 19.2 /11/ заасан үүрэг
6	Хуулиар хүлээсэн онцлог чиг үүргийн биелэлт		Хууль, журамд заасан үүргийг бүрэн биелүүлэх	ҮЦЗЗ-ийн тухай хуульд заасан 24.3 /4/, 25.4 /3/

7	Тайлангийн жилд хууль тогтоомж зөрчин зөрчил дутагдал гаргасан эсэх	Тоо, хувь	ҮЦЗЗ-ийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журам, зааврыг зөрчихгүй байх	ҮЦЗЗ-ийн тухай хууль болон бусад хууль тогтоомж
8	Хороонд тайлан тэнцэл, мэдээ судалгааг хугацаанд нь ирүүлсэн байдал	Тоо, хувь	Хугацаатай мэдээ, тайланг тухай бүр үнэн зөв шуурхай гаргаж ирүүлэх	ҮЦЗЗ-ийн тухай хуулийн холбогдох заалт /19.2.5, 19.2.7, 25.4.3 /
9	Хорооноос тухайн жилд гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт	Тоо, хувь	Тухайн жилд Хорооноос гаргасан тогтоолоор өгөгдсөн үүргийг бүрэн биелүүлж, тайлан мэдээг хугацаанд нь ирүүлэх	ҮЦЗЗ-ийн тухай хууль болон холбогдох заавар, журам

**“ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” /БАЙГУУЛЛАГЫН/ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ЖУРАМ**

Үнэт цаасны хорооны 2005 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 30 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн төв” ХХК /байгууллагын/-ийн ажлыг дүгнэхдээ үзүүлэлт тус бүрийн дор заасан журмаар дүгнэнэ.

1-р үзүүлэлт: Жилийн санхүүгийн тайлан тэнцлээр гарсан эргэлтийн хөрөнгийн хэмжээг хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулан хувиар гаргана. Өнгөрсөн оноос өссөн буурсныг тоо, хувиар жишиж дүгнэнэ.

2-р үзүүлэлт: Эрсдлийн санг хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиар байгуулж тусгай дансанд байршуулж, шаардлагатай үед зохих шийдвэр гарган, түүний дагуу зарцуулсан байдал. Санд төвлөрүүлсэн хөрөнгө 5%-д хүрсэн эсэхийг тоо ба хувиар гаргаж өнгөрсөн онтой зэрэгцүүлж тооцно.

3-р үзүүлэлт: Тухайн жилд хийсэн үнэт цаасны гүйлгээний дүнгийн хэмжээгээр өнгөрсөн онтой харьцуулан дүгнэнэ. Энэ нь үзүүлэлт нь Хөрөнгийн биржийн гүйлгээний дүнтэй тохирч байх шаардлагатай.

4-р үзүүлэлт: Үнэт цаас гаргагч болон бусад этгээдүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр ногдол ашиг, ногдол хувь, бусад мөнгөн хөрөнгийг эздэд нь тараах, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдсон үйлчилгээг зохих хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн гүйлгээний дүнг гарган урьд жилүүдтэй харьцуулж дүгнэнэ.

5-р үзүүлэлт: Энэ үзүүлэлтийг тооцохдоо эргэлтийн хөрөнгийг богино хугацаат өглөгөд харьцуулж тооцно.

6, 7-р үзүүлэлт: Хуулиар нийтлэг болон онцлог чиг үүрэгт заасан үүргээс хэдий нь биелүүлсэнийг тоогоор болон хувиар гаргаж харьцуулж үзнэ.

8-р үзүүлэлт: Тайлангийн жилд хууль тогтоомж зөрчиж зөрчил дутагдал гаргасан байдлыг холбогдох шалгалтын материал, хөдөлмөрчдөөс ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний мөрөөр шалгасан дүн зэргийг үндэслэн тоо, хувиар гарган дүгнэнэ.

9-р үзүүлэлт: Хууль, тогтоомжийн дагуу гаргах болон Хорооноос шаардсан мэдээ, тайлан, тэнцлийг хугацаанд нь гаргаж ирүүлсэн байдлыг тоо, хувиар гаргаж тооцно.

10-р үзүүлэлт: Хорооноос тухайн жилд гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлтийг уг байгууллагатай холбоотой заалт нэг бүрээр биелэлтийг гарган хэдэн заалтаас хэдийг хугацаанд нь бүрэн биелүүлэв. Хэдийг нь хугацаа хэтрүүлсэн гэх мэт нарийвчлан гаргаж дүгнэнэ.

ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хууль журмаар тавигдсан шаардлага	Тайлбар үндэслэл	
1	Эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь	Мян. төг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 30 хувиас доошгүй	ҮЦХ-ны 2003.08.06-ны өдрийн 59 -р тогтоолоор батлагдсан журам	
2	Эрсдлийн сан	Мян. төг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувиас доошгүй хэмжээгээр байгуулах	ҮЦЗЗТХууль болон 2003.08.06-ны өдрийн 59 тоот тогтоолоор баталсан журам	
3	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт	Үнэт цаасны гүйлгээний дүн	Мян. төг	Үйл ажиллагааны зардлаа нөхөхүйц шимтгэлийн орлого олох хэмжээнд хүргэх	ҮЦЗЗ-ийн тухай хууль, Компанийн тухай хууль
		Зардал	Мян. төг	Үйл ажиллагааг хэвийн явуулахуйц хэмжээний байх	--
		Ашиг, алдагдал	Мян. төг	Үр ашигтай ажиллах	--
4	Арилжаанд оролцсон байдал	Тоо, хувь	Жилд хэдэн удаа арилжаа явагдсан бүгдэд нь оролцох зорилт тавина	ҮЦЗЗТ хууль	
5	Санхүү, төлбөрийн чадварын коэффициент	Коефф.	Төлбөр түргэн гүйцэтгэх бололцоотой хэмжээний эргэлтийн хөрөнгөтэй байх	Санхүүгийн тайлан тэнцэл, мэдээ судалгааг үндэслэнэ	
6	Хуулиар хүлээсэн үндсэн чиг болон тодорхой чиг үүргийн хэрэгжилт	Тоо, хувь	ҮЦЗЗТ болон Компанийн тухай хуулийн заалтыг биелүүлэх, хууль журмыг бүрэн биелүүлэх	ҮЦЗЗТ хуулийн 19.2 /11/ 27.1, 27.3/4/ заалт, Компанийн тухай хуулийн холбогдох заалт	
7	Иргэд харилцагчдаас тухайн компанитай холбогдон гарсан өргөдөл гомдлын барагдуулалт	Тоо, хувь	Иргэд харилцагчдаас Хороо, биржид болон уг компанид ирсэн гомдлыг бүрэн барагдуулж, хариуг өгөх. Эдгээр өргөдлийг	ҮЦЗЗТХ, Компанийн тухай Хөдөлмөрчдийн эрэлт хүсэлтийг барагдуулах тухай хуулиудын холбогдох заалтууд	

			барагдуулах талаар Хорооноос өгсөн үүргийг биелүүлэх	
8	Тайлангийн жилд хууль, тогтоомж, заавар, журам зөрчиж зөрчил дутагдал гаргасан эсэх	Тоо, хувь	ҮЦЗЗТХ болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа хийхгүй байх, хууль, журмын дагуу харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах	ҮЦЗЗТХ бусад хууль, тогтоомжийг сайтар мөрдөх
9	Хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт	Тоо, хувь	Хорооноос гаргасан тогтоол шийдвэрийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж тайлагнах	ҮЦЗЗ-ийн тухай, Компанийн тухай, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулиудын холбогдох заалтууд

**“ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН
БИЕЛЭЛТИЙГ ГАРГАХ ЖУРАМ”**

Үнэт цаасны брокер, дилерийн компанийн үйл ажиллагааг дүгнэхдээ 9 үзүүлэлтээр дүгнэж /хагас, бүтэн жилээр/ байр эзлүүлж дүгнэнэ.

1-р үзүүлэлт. Хувь нийлүүлсэн хөрөнгийн 30%-иас доошгүй хэмжээнд эргэлтийн хөрөнгийг бүрдүүлсэн байна. Үүнийг тайлан тэнцлийн үзүүлэлтээр тооцож, өнгөрсөн онтой харьцуулан тоо, хувиар гаргаж зэрэгцүүлэн өсөлт, бууралтыг тооцно.

2-р үзүүлэлт. Хууль журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг тоо ба хувиар гаргаж дүгнэнэ.

3-р үзүүлэлт. Үнэт цаасны брокер, дилерийн компаниудын арилжаанд оролцсон байдлыг дүгнэх гол үзүүлэлт бөгөөд арилжаанд оролцож хийсэн арилжааны дүнгээр тооцож төлөвлөсөн хэмжээ, өнгөрсөн жилийн гүйцэтгэлтэй харьцуулж, өсөлт, бууралтыг тооцно.

- Зардлын тайлан тэнцэлд гаргасан хэмжээгээр авч өнгөрсөн оны гүйцэтгэл, төлөвлөсөн хэмжээтэй жишиж тооцно.

- Ашгийн татвар төлсний дараахь цэвэр ашгаар авч тооцно.

4-р үзүүлэлт. Уг БДК нь тухайн жил хэдэн удаа арилжаа хийгдсэнээс хэдэд нь оролцсон байдлыг коэффициентоор гаргана. Аль болох дээшлэх /100% дөхөх буюу 1-рүү ойртох / тутам сайн гэсэн үнэлгээ авна.

5-р үзүүлэлт. Санхүүгийн тайлан тэнцлийг үндэслэн_төлбөрийн чадварын үзүүлэлт болох эргэлтийн хөрөнгө болон цэвэр хөрөнгийн харьцаагаар тооцно. Харьцааг тооцоходоо эргэлтийн хөрөнгийг богино хугацаат өр төлбөрт харьцуулан тооцно.

6-р үзүүлэлт. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2/11/, 27.1, 27.3-т заасан чиг үүргүүдээс хэдэн үүргээс хэдийг биелүүлсний тоо, хувиар гаргаж өмнөх жилтэй зэрэгцүүлэн дүгнэнэ.

7-р үзүүлэлт. Хороо, Хөрөнгийн бирж болон өөрт нь иргэд харилцагчдаас хэдэн өргөдөл, гомдол ирсэн, үүний хэдийг барагдуулж зохих хариу өгсөн байдлыг гарган тоо, хувиар тооцож дүгнэнэ.

8-р үзүүлэлт. Тайлангийн жилд тухайн компани хууль зөрчиж дутагдал гаргасан эсэхийг Хороонд харилцагч, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу хийсэн шалгалт болон бусад мэдээлэл, ээлжит үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг үндэслэн тооцно.

9-р үзүүлэлт. Хорооноос гарсан шийдвэрээр уг компанид хэдэн заалт бүхий үүрэг өгөгдсөн, үүнээс хэдийг хэрэгжүүлж тайлагнасныг тооцон хувиар гаргаж дүгнэнэ.

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ КОМПАНИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хууль, журмаар тавигдах шаардлага	Үндэслэл, тайлбар
1	Эргэлтийн хөрөнгийн хэмжээ	Мян.төг Эзлэх /хувь/	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнд эргэлтийн хөрөнгийн /мөнгөн болон түргэн борлогдох/ эзлэх хувийг 50%-д хүрсэн байх	ҮЦЗЗТХ-ийн 28.1, холбогдох заавар, журам
2	Эрсдлийн сан	Сая. төг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнд 3%-иас багагүй хэмжээгээр байгуулах	ҮЦХ-ны 2003.08.06-ны өдрийн 59 дүгээр тогтоол
3	Үнэт цаас гаргагч компани, байгууллагатай байгуулсан гэрээний дагуу бэлдсэн танилцуулга, зөвлөгөө өгсөн байдал	Тоо	Үнэт цаас гаргагч компани, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ хийж мэргэжлийн зөвлөлгөө өгөх. Үнэт цаасны танилцуулгыг хууль, журмын дагуу иж бүрэн чанартай бэлтгэж өгөх	ҮЦЗЗТ хуулийн 3.1.12; 19; 20; 28.2
4	Үнэт цаас гаргагчаас худалдан авч борлуулсан үнэт цаасны дүн	Мян.төг	Үнэт цаас гаргагчдаас худалдан авч, борлуулах үнэт цаасны хэмжээг нэмэгдүүлж, орлого, шимтгэлээр зардлаа нөхөх	ҮЦЗЗТХ-ийн 3.1.12
5	Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	Сая. төг	Андеррайтерийн үйл ажиллагаа явуулсан дүнд олсон орлогыг нэмэгдүүлэх, зардлаа нөхөх	ҮЦЗЗТХ-ийн 3.1.12; 28.2 компанийн тухай хууль
	Түүнтэй холбоотой зарлага	Сая. төг	Андеррайтерийн үйл ажиллагаа явуулахад зориулсан зардлыг ариг гамтай зарцуулах	--
	Үйл ажиллагааны ашиг/+, алдагдал -/	Сая. төг	Үр ашигтай ажиллах	--

6	Хороонд санхүүгийн тайлан тэнцэл, мэдээ судалгааг хугацаанд нь гаргаж ирүүлсэн байдал	Тоо, хувь	Хагас жилийн болон жилийн санхүүгийн тайланг үнэн зөв гарган аудит хийлгэн /бусад шаардсан мэдээ, судалгааг / хугацаанд нь ирүүлэх	ҮЦЗЗТ хуулийн 19.2.1; 19.2.5
7	Тайлант жилд хууль, тогтоомж зөрчиж зөрчил дутагдал гаргасан эсэх	Тоо, хувь	Хууль холбогдох хууль, заавар журмыг мөрдөж зөрчил дутагдал гаргахгүй үйл ажиллагаа явуулах	ҮЦЗЗТХ, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хууль
8	ҮЦХ-ноос гаргасан тогтоол шийдвэрийн биелэлт	Тоо, хувь	Андеррайтерийн холбогдолтой гарсан тогтоол шийдвэр, заавар, журмыг хэрэгжүүлж хугацаанд нь мэдээлэх	ҮЦЗЗТХ-ийн 15.1

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ КОМПАНИ /БАЙГУУЛЛАГА/-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ЖУРАМ**

Үнэт цаасны зах зээлд андеррайтерийн ажиллагаа эрхлэх компани /байгууллага/-ийн үйл ажиллагааг дүгнэхэд доорхи журам баримтлана.

1-р үзүүлэлт. Үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгөний дүнд мөнгөн болон түргэн борлогдох эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийг гүйцэтгэлээр тооцож, дүгнэнэ.

Банкны болон бусад үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын тухайд зөвхөн андеррайтерийн үйл ажиллагаатай холбогдох буюу түүнд зориулагдсан хөрөнгөөр тооцож /тусад нь салган/ гаргана.

2-р үзүүлэлт. Хувь нийлүүлсэн хөрөнгийн /зөвхөн андеррайтерийн үйл ажиллагаанд компани/ дүнгийн 3 хувиас доошгүй хэмжээгээр байгуулж тайлан тэнцэлд туссан гүйцэтгэлээр тооцно.

3-р үзүүлэлт. Хэрэв үнэт цаас гаргагч компани, байгууллагатай гэрээ байгуулж танилцуулга бэлдэж өгсөн, зөвлөлгөө өгсөн бол гүйцэтгэлийг тоогоор гаргаж харьцуулна.

4-р үзүүлэлт. Үнэт цаас гаргагчаас худалдан авч, цааш нь борлуулсан үнэт цаасны гүйлгээний дүн, тэдгээр нь уг үнэт цаас гаргагч тус бүрийн шинээр нэмж гаргасан буюу нийт гаргасан үнэт цаасны дүнд эзлэх хувийг компани тус бүрээр дүгнэж, гаргана.

5-р үзүүлэлт. Андеррайтерийн үйл ажиллагаа явуулсны үр дүнд олсон орлого, уг үйл ажиллагаатай холбогдолтой зардлыг тусад нь салгаж /бусад үйл ажиллагаа давхар эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын тухайд/ энэ үзүүлэлтийг тооцох ба ашгийг татвар төлсний дараах цэвэр ашгаар тооцно.

6-р үзүүлэлт. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.5, 19.2.7, 25.4.3-р зүйл заалтууд болон албан бичиг тоотоор шаардлага, мэдээ, тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь ирүүлсэн байдлыг компани тус бүрээр гаргаж дүгнэнэ.

7-р үзүүлэлт. Тайлангийн жилд андеррайтерийн үйл ажиллагаа үйлчилгээтэй холбогдсон , хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо, учирсан хохирлын хэмжээг холбогдох үзлэг шалгалтын материал, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний мөрөөр хийгдсэн шалгалтын дүн зэргийг үндэслэн тоо, хэмжээг тооцон урьд жилийн гүйцэтгэлтэй харьцуулж дүгнэнэ.

8-р үзүүлэлт. Хорооноос тухайн жилд болон байнга мөрдөхөөр гаргасан дүрэм, журам, баталсан тогтоолын биелэлтийг холбогдох заалт нэг бүрээр гаргаж дүгнэнэ.